



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

ИНФОГРАФИК 2022 I-VIII



ХҮН АМ

2022 оны эхний 8 сард Сүхбаатар дүүрэгт 1499 хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт 10.4 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 нэгжээр буурчээ.

1000 ХҮНД НОГДОХ



Төрөлт 10.4

Нас баралт 3.6

Ердийн цэвэр өсөлт 6.8

Оны эхний 8 сарын байдлаар нас баралт 525 бүртгэгдэж, 2021 оны мөн үеэс 50-иар (8.7%) буурсан бол өмнөх сараас 56-гаар (11.9%) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, сүүлийн 5 жилийн эхний 8 сард

6.8

Хамгийн бага

Хамгийн их

10.9

Ердийн цэвэр өсөлт: Хүн амын тооны өсөлт, бууралтыг харуулна.



ТӨРСӨН ХҮҮХЭД

2021
I-VIII



2022
I-VIII

1665

1499↓

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 8 сард 1486 эх амаржин, 1499 хүүхэд шинээр мэндэлж, 10-н амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн 19 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 тохиолдлоор (11.8%) нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

13

0-1 хүртэлх насны

1-5 хүртэлх насны

6↑

-

Эхийн эндэгдэл

ЭХИЙН ТӨРӨЛТ

6↑

Гэрийн төрөлт

Хяналтгүй төрөлт

8↑

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 10.2 хувиар буурчээ. Гэрийн төрөлтийн 6, хяналтгүй төрөлтийн мөн 8 тохиолдол бүртгэгдсэн байна.



ЭРҮҮЛ МЭНД

НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

2021 I-VIII	Халдварт өвчин	184	
	Цочмог халдварт өвчин	11090	11274
2022 I-VIII	Халдварт өвчин	193	12825
	Цочмог халдварт өвчин	12632	

2022 оны эхний 8 сард 10.0 мянган хүн тутмын 874 нь цочмог, 13 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН - 193



ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН - 12632



Коронавирус халдварын тохиолдол 2022 оны 1 сард 8765, 2 сард 2641, 3 сард 651, мөн 6 сард 360 тохиолдол бүртгэгдсэн сөрөг үзүүлэлттэй байсан бол 4,5,7,8 дугаар саруудад бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ



Ehalamj системээр 2022 оны 8 сард олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ

	2022 I	2022 VIII
Халамжийн тэтгэвэр	1 815 хүн 522.2 сая төг	1 849 хүн 519.9 сая төг
Алдарт эх одонгийн мөнгө	7 939 хүн 971 сая төг	2 хүн 0.2 сая төг
Алдар цолтон ахмад настан хөнгөлөлт	5 хүн 1.2 сая төг	3 хүн 0.8 сая төг
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	51 525 хүн 5 152.5 сая төг	52 459 хүн 5 245.9 сая төг
Бусад тэтгэмж	17 516 хүн 1 340.9 сая төг	9 695 хүн 739.8 сая төг



НИЙГМИЙН ДААТГАЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

	2021 I-VIII	2022 I-VIII
ОРЛОГО, тэрбум төгрөг	224.4	255.7 ↑
ЗАРЛАГА, тэрбум төгрөг	97.0	118.3 ↑
ОЛГОСОН ТЭТГЭВЭР	20.2	21.2 ↑
Тэтгэвэр авагчийн тоо, мянган хүн		
	76.9	99.1 ↑
ОЛГОСОН ТЭТГЭМЖ	18.8	22.0 ↑
Хамрагдсан хүн, мянган хүн		
	20.1	19.2 ↓




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

2021 I-VIII 437 2022 I-VIII 462↑



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2022 I-VIII



Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 8 сарын эцэст 462 болж, өмнөх оны мөн үеэс 25-аар (5.7%) өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 8 сард 284 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх сараас 34-өөр (13.6%) нэмэгджээ.



БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2021 I-VIII

1282



2022 I-VIII

2500↑

1-р хэлтэс

2-р хэлтэс

(1-9 дүгээр хороо)

(10-20 дугаар хороо)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 1581 (63.2%)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 919 (36.8%)

Илрүүлэлт 35.5%

Илрүүлэлт 42.9%

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 8 сард 1-р хэлтэст 1581, 2-р хэлтэст 919, нийт 2500 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 1218 хэргээр 1.9 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 38.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар нэмэгджээ.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 11917 бүртгэгдсэн байна.



БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, төрлөөр

2021 I-VIII

2022 I-VIII

84

108↑

Объектын

7

22↑

Хогны

5

65↑

Өнжмөл шар өвсний



БҮРТГЭГДСЭН ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА

16

1↓

Үер ус, халиа дошин



2022 оны эхний 8 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 108, хогны 22, өнжмөл шар өвс шатсан 65, халиа дошны 1, нийт 196 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 84-өөр буюу 1.7 дахин нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гал түймрийн өсөлтөд өнжмөл шар өвс шатсан дуудлага 60-аар буюу 13.0 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, сая төгрөг



Төлөвлөгөө 193 217.3

Гүйцэтгэл 169 188.0

Биелэлт 87.6%

2022 оны эхний 8 сард дүүргийн төсөвт 169.2 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 87.6 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 99.9 хувийг урсгал орлого, 0.1 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна.

Харин урсгал орлогын 99.3 хувийг татварын орлого, 0.7 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ.

ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, сая төгрөг



Төлөвлөгөө 193 217.3

Гүйцэтгэл 169 188.0

Биелэлт 87.5%



Оны эхний 8 сарын байдлаар төвлөрсөн орлогыг 100.0% урсгал зардалд зарцуулаад байна. Урсгал зардлын дийлэнх буюу 99.7%-ийг бараа үйлчилгээний, 0.3%-ийг бусад зардал эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын дийлэнх буюу 71.5%-ийн нийслэлд төвлөрүүлсэн орлогод, 2.6%-ийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 0.3%-ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд, 26.2%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулжээ.



АЖ ҮЙЛДВЭР (*урьдчилсан гүйцэтгэл)

2021 I-VIII Нийт үйлдвэрлэл 2 380.1 тэрбум
Нийт борлуулалт 4 935.7 төгрөг



2022 I-VIII Нийт үйлдвэрлэл 2 291.2* тэрбум
Нийт борлуулалт 7 480.1* төгрөг

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

2021 I-VIII

2022 I-VIII

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (14.3%↑)

1 881.6
тэрбум төгрөг



2 150.9*↑
тэрбум төгрөг

БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (72.0%↓)


495.9
тэрбум төгрөг



139.3*↓
тэрбум төгрөг

ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (61.6%↓)

2.6
тэрбум төгрөг



1.0*↓
тэрбум төгрөг



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ



Цэвэрлэсэн зам
талбай 436.8 мян.м2
Зарцуулсан хөрөнгө
1 999.3 сая төгрөг

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, байршлаар, 2022 I-VIII

24 484.0 тн Орон сууцнаас



Гэр хорооллоос 14 523.0 тн



9 120.3 тн Зуслангаас



2022 оны эхний 8 сард дүүргийн хэмжээнд 48.1 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9.7 мянган тонноор буюу 25.3 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 50.9 хувийг орон сууцнаас, 30.2 хувийг гэр хорооллоос, 18.9 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ.

Хог тээвэрлэлтэд нийт 1999.3 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 574.4 сая төгрөгөөр (40.3%) өссөн үзүүлэлттэй байна.

